

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэсийн илч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/013/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Л.Мандахнаран
Утас: 88548896 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/211
тантай _____ -ны № _____ -т

ТЭСИЙН ИЛЧ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ГАЛБАДРАХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тэсийн илч ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн XXVIII/39 дүгээр тогтоолоор компанийн өмчлөлийг Цэцэрлэг сумын ИТХ-д шилжүүлсэн байна.

Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Цэцэрлэг сумын дулааны төвийн хэрэглээнд зориулж нийлүүлэх нүүрсний үнийг 100 хувь хөнгөлсөн ба 2024 онд 1,529.5 тн нүүрс хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 121,023.3 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 121,023.3 мянган төгрөгийн 5 алдааг зарруулж, 1 албан шаардлага хүргүүлж, нийцлийн аудиттай холбогдолтой 5 зөвлөмж өглөө.

Бусад асуудлын хэсэг

Тэсийн илч ХХК нь тайлант жилд батлагдсан орлогын төлөвлөгөөг 4.5 хувиар давуулж биелүүлсэн ба зардлын гүйцэтгэл 100.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЗБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,204,943.76	1,610,269.08
1.1.2	Дансны авлага	62,602,603.12	37,311,288.12
1.1.6	Бараа материал	31,458,194.45	32,635,968.31
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	95,265,741.33	71,557,525.51
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,001,772,252.83	2,977,886,797.20
1.2.2	Биет бус хөрөнгө	18,922,000.00	18,768,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,020,694,252.83	2,996,654,797.20
1.3	Нийт хөрөнгийн дүн	3,115,959,994.16	3,068,212,322.71
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	41,263,863.93	299,228.50
2.1.1.3	Татварын өр	17,621,660.81	15,186,012.77
2.1.1.4	НДШ - ийн өглөг		7,618,356.98
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	58,885,524.74	23,103,598.25
2.2	Өр төлбөрийн нийт дүн	58,885,524.74	23,103,598.25
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч	-	-
2.3.1	-төрийн	3,632,203,450.00	3,632,203,450.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	256,113,021.51	256,113,021.51
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	653,088,371.06	953,988,371.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,484,330,373.15)	(1,797,196,118.11)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,057,074,469.42	3,045,108,724.46
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	3,115,959,994.16	3,068,212,322.71

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	410,279,702.04	429,253,797.18
2	Борлуулалтын өртөг	647,277,258.30	660,691,763.55
3	Нийт ашиг (алдагдал)	(236,997,556.26)	(231,437,966.37)
8	Бусад орлого	381,000.0	643,046.50
10	Ерөнхий ба удирдлагын зардал	60,772,322.0	81,976,120.45
11	Санхүүгийн зардал	57,000.0	94,704.64
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(297,445,878.26)	(312,865,744.96)
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	(297,445,878.26)	(312,865,744.96)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(297,445,878.26)	(312,865,744.96)
24	Орлогын нийт дүн	(297,445,878.26)	(312,865,744.96)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,632,203,450.0	256,113,021.51	633,138,371.06	-1,102,565,991.09	3,418,888,851.48
2	Залруулсан үлдэгдэл	3,632,203,450	256,113,021.5	633,138,371	(1,102,565,991)	3,418,888,851.48

3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0		-381,764,382.06	-381,764,382.06
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0		19,950,000.00		19,950,000.00
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,632,203,450	256,113,021.51	653,088,371.06	(1,484,330,373.15)	3,057,074,469
2	Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.00	0.00
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	-312,865,744.96	-312,865,744.96
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	300,900,000.0	0.00	300,900,000.00
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,632,203,450	256,113,021.51	953,988,371.06	-1,797,196,118.11	3,045,108,724.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	433,831,791	497,971,412
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	432,484,128.8	497,686,411.8
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,347,661.7	285,000.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	460,436,973	497,301,982
1.2.1	Ажиллагчдад төлсөн	193,681,293.0	195,087,315.0
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	56,728,252.8	60,092,252.9
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	38,522,717.4	45,578,090.5
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	67,288,339.6	62,081,058.1
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	35,411,683.0	82,832,000.0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	21,424,244.3	39,978,774.5
1.2.9	Бусад мөнгөн зарлага	47,380,442.8	11,652,491.2
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,605,182.31)	669,429.65
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	1,135,896
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		1,050,000.0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		85,895.67
2.2	Мөнгөн зарлагын дүн	3,278,000.0	1,400,000.0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,278,000.0	1,400,000.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,278,000.0	-264,104.3
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	0.0	0.0
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	0.0
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-29,883,182.3	405,325.32
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	31,088,126.1	1,204,943.76

6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,204,943.8	1,610,269.08
---	--	--------------------	---------------------

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Халаалтын орлого	373,150,400.00	393,692,024.18	20,541,624.18
2	Цэвэр усны орлого	9,600,000.00	9,068,070.00	(531,930.00)
3	Бохир усны орлого	23,874,100.00	25,413,703.00	1,539,603.00
4	Түрээсийн орлого	3,960,000.00	1,080,000.00	(2,880,000.00)
	Орлогын дүн	410,584,500.00	429,253,797.18	18,669,297.18
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	235,344,200.00	237,640,100.00	(2,295,900.00)
2	НДШимтгэлийн зардал	35,455,700.00	34,060,000.00	1,395,700.00
3	Нүүрс	0.00	0.00	-
4	Шатахуун	15,000,000.00	20,470,500.00	(5,470,500.00)
5	Тээврийн зардал	24,000,000.00	25,444,400.00	(1,444,400.00)
6	Гэрэл цахилгаан	50,000,000.00	55,368,600.00	(5,368,600.00)
7	Бичиг хэрэг	500,000.00	477,800.00	22,200.00
8	Цахилгаан холбоо	1,200,800.00	648,200.00	552,600.00
9	Албан томилот	500,000.00	1,385,000.00	(885,000.00)
10	Цэвэрлэгээний материал	500,000.00	298,200.00	201,800.00
11	Хөдөлмөр хамгаалал	8,950,000.00	7,501,800.00	1,448,200.00
	Хоол хүнс	5,000,000.00	4,982,142.14	17,857.86
12	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-
13	Төлбөр хураамж/Аудитын төлбөр/	1,800,000.00	1,800,000.00	-
14	ТУЗ зардал	6,175,100.00	4,248,500.00	1,926,600.00
15	Үйлдвэрийн зориулалтаар ус ашигласны төлбөр	400,000.00	330,000.00	70,000.00
16	Усны шинжилгээний төлбөр	429,500.00	99,500.00	330,000.00
17	Сэлбэгийн зардал	10,000,000.00	12,438,600.00	(2,438,600.00)
18	Тээврийн хэрэгсэлийн татвар,даатгал, агаарын бохирдол, оншилгоо	208,500.00	0.00	208,500.00
19	ЭХЗЗ-ийн үйлчилгээний хөлс	1,500,000.00	1,627,000.00	(127,000.00)
20	ҮХХ-ийн албан татвар	459,500.00	459,500.00	-
21	Газрын төлбөр	80,000.00	16,600.00	63,400.00
22	Праграммын лиценз архив	500,000.00	308,000.00	192,000.00
23	Хог хаягдалын хураамж	50,000.00	0.00	50,000.00
24	Элэгдлийн зардал	334,612,300.00	324,939,500.00	9,672,800.00
25	Үйлчилгээний хөлс	2,600,000.00	1,875,600.00	724,400.00
26	Хог хаягдал үнс нурам зайлуулах зардал	2,749,200.00	2,700,000.00	49,200.00
27	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	741,014,800.00	742,119,542.14	(1,104,742.14)
28	Үйл ажиллагааны бус орлого, зардал			
29	Татварын өмнөх ашиг, /алдагдал/	-330,430,300.00	-312,865,744.96	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 121,023.3 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 121,023.3 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, нийцлийн аудиттай холбогдолтой 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний дүн харилцахын хуулганаас 1,050.0 мянган төгрөгөөр зөрүүтэй алдааг залруулсан
- Мөнгөн гүйлгээний журналын бичилт 69,187.9 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн алдааг залруулсан
- Татварын е-баримт системд борлуулалт дутуу шивсэн 50,423.4 мянган төгрөгийг залруулсан.
- Орлого 362.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 11,344.9 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад байршуулаагүй, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 7,013.0 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Компанийн бизнес төлөвлөгөөг батлахтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тэсийн илч ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор компанийн бизнес төлөвлөгөөг батлахдаа тус компаний мөрдөж байгаа, үнэ тарифын үндэслэл, тооцооллыг бүрэн хянаагүйгээс 2024 онд 330,466.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан, гүйцэтгэх удирдлага батлагдсан зардлыг 1,104.7 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил нь Засгийн газрын “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 388 дугаар тогтоолын 2.4 “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, мөнгөн хөрөнгийн удирдлагыг дээшлүүлж, үр өгөөжийг өсгөх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг эрс нэмэгдүүлэх арга хэмжээ авах.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн бизнес төлөвлөгөөний үндэслэлийг сайтар хэлэлцэн батлах, батлагдсан төлөвлөгөөг хэтрүүлэхгүй биелэлтийг ханган ажиллах.

2. И-баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын худалдан авалттай холбоотой 2,517.8 мянган төгрөгийн гүйлгээ нь цахим и-баримтгүй байгаа нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 зааснаар бараа материалын худалдан авалтыг дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт аар анхан шатны баримт бүрдүүлж хэвших.

3. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайлан, компанийн батлагдсан зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг хугацаа хоцроож байршуулсан, байгууллагын батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг, хамт сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 34, зарлагын 18 гүйлгээний мэдээллийг огт мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.11, 3.1.14, 3.2.10 4.1.12 заалтуудтай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 29 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасан хугацааг баримтлан мэдээлж байх.

4. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Тэсийн илч ХХК нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.4 заалтад заасан ТУЗ-ийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон

эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг ил тод, цахим хуудсаар мэдээлээгүй.

Өгсөн зөвлөмж:

Хууль, журамд заасан мэдээллүүдийг ил тод, цахим хуудсаар мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний дүн харилцахын хуулганаас 1,050.0 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	1,050.0			1	1,050.0	1	1,050.0		
Мөнгөн гүйлгээний журналын бичилт 69,187.9 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	69,187.9			1	69,187.9	1	69,187.9		
Татварын е-баримт системд 50,423.4 мянган төгрөгийн борлуулалт дутуу	1	50,423.4	1	50,423.4			1	50,423.4		
Орлого 362.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	362.0	1	362.0			1	362.0		
Дүн	4	121,023.3	2	50,785.4	2	70,237.9	4	121,023.3		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тэсийн илч ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор компанийн бизнес төлөвлөгөөг батлахдаа тус компаний мөрдөж байгаа, үнэ тарифын үндэслэл, тооцооллыг бүрэн хянаагүйгээс 2024 онд 330,466.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан, гүйцэтгэх удирдлага батлагдсан зардлыг 1,104.7 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зөрчил	1	0.0					1	0.0

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад байршуулаагүй, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 7,013.0 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн.	1	0.0			1	0.0		
Бараа материалын худалдан авалттай холбоотой 2,517.8 мянган төгрөгийн ажил гүйлгээ и-баримтаар баталгаажуулаагүй.	1	0.0					1	0.0
Шилэн дансны цахим хуудсанд 56 мэдээлэл байршуулаагүй.	1	0.0					1	0.0
Ахмадын сан байгуулаагүй байна.	1	0.0					1	0.0
Төрийн хэмнэлтийн хуулийн 20-р зүйлд заасан мэдээллийг ил тод, цахимаар мэдээлээгүй.	1	0.0					1	0.0
Дүн	6	0.0			1	0.0	5	0.0



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 44/10270449

Мөрөөт сүм

ХАА. 2025/013 /МН. ИБ. 01011

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Тэсийн-Илч ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тэсийн-Илч ХХК нь Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад байршуулаагүй, шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгөөр хэтэрсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, бэвтэн гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлах, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим оруулж, баталгаажуулах;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тэсийн-Илч ХХК-ийн захирал А. Галбадрах, нягтлан бодогч Б. Сувд-Эрдэнэ нарт даалгаа.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А. ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Л. МАНДАХНАРАН



6724070631